



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл, холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баттөмөр

-Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Л.Болд

-Улсын Их Хурлын гишүүн

М.Оюунчимэг

-Улсын Их Хурлын гишүүн

Д.Тэрбишдагва


-Улсын Их Хурлын гишүүн

Л.Энх-Амгалан

-Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа туслалцаа авах чиглэлээр холбогдох байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Б.Баттөмөр/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ж. ГАНБААТАР



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2020 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

М.Оюунчимэг

-Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Б.Баттөмөр

-Улсын Их Хурлын гишүүн

Л.Болд

-Улсын Их Хурлын гишүүн

Ж.Ганбаатар

-Улсын Их Хурлын гишүүн

Ц.Гарамжав

-Улсын Их Хурлын гишүүн

Я.Содбаатар


-Улсын Их Хурлын гишүүн

Д.Эрдэнэбат

-Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжилтэн, албан хаагчийг оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /М.Оюунчимэг/-т зөвшөөрсүгэй.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ж.ГАНБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:


Нэг.Банкны салбарыг чадавхжуулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монголбанк /Б.Лхагвасүрэн/-нд чиглэл болгосугай:

1/“Банкны салбарыг чадавхжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийг баталж, хэрэгжилтийг хангах;

2/шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулах.

Хоёр.Энэ тогтоолын хэрэгжилтийг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Монголбанк /Б.Лхагвасүрэн/-нд даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ж.ГАНБААТАР